

Цэргийн алба хаагчдын нийгмийн хамгааллын асуудал, сайжруулах арга зам

П.Дэлгэрмаа

*Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн
Бодлогын дүн шинжилгээний төв*

ABSTRACT

Military personnel play a crucial role in safeguarding national independence and security; therefore, their social protection is not merely a matter of individual welfare but an essential factor of defense capability and national security. The social protection system encompasses a wide range of guarantees, including salaries, pensions and allowances, healthcare services, housing provision, family support, education, and psychological assistance, tailored to the unique duties and risks of military service. Developing a comprehensive social protection framework for military personnel and adopting best practices from developed countries are of strategic importance for strengthening defense capacity. Therefore, in order to improve the social security of military personnel, the government's policy implementation and current situation are compared and analyzed with the experience of developed countries, and ways to further implement them are sought.

Keywords: *Housing support, salary, pension, healthcare services, education, psychological support, remote units, professional allowance, defense policy, human resource security.*

УДИРТГАЛ

Нийгмийн хамгаалал гэдэг нь хувь хүн, өрх гэр, нийт иргэдийн эдийн засаг, нийгмийн наад захын хэрэгцээг хангах, гэнэтийн эрсдэл, хүндрэл бэрхшээл, амьжиргааны тогтвортой байдалд нөлөөлөх хүчин зүйлээс хамгаалах төрийн бодлого, арга хэмжээний цогц тогтолцоо юм.

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ)-ын тодорхойлолтоор: “Нийгмийн хамгаалал нь бүх хүмүүсийг өвчин, жирэмслэлт, ажилгүйдэл, хөдөлмөрийн чадвар алдалт, хөгшрөлт, хөдөлмөрийн осол, асрамжийн хэрэгцээ зэрэг нийгмийн эрсдэлээс хамгаалж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, орлогын баталгаагаар хангах нийгмийн бодлогын тогтолцоо” гэж заасан байдаг¹. Өөрөөр хэлбэл, нийгмийн хамгаалал нь зөвхөн эдийн засгийн баталгааг хангах төдийгүй хүний эрх, нийгмийн шударга ёсыг хамгаалах, тогтвортой хөгжлийг хангах үндэсний бодлогын салшгүй хэсэг юм.

¹ World Social Protection Report 2017–19: Universal social protection to achieve the Sustainable Development Goals. Geneva: ILO

Батлан хамгаалах салбар дахь нийгмийн хамгааллын онцлог

Цэргийн алба хаагчдын нийгмийн хамгаалал нь иргэний алба хаагчдаас хэд хэдэн онцлогоор ялгагдана. Үүнд:

- Үүргийн онцлог: Цэргийн алба нь улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдлын баталгаа тул өндөр эрсдэл, бие махбодын болон сэтгэл зүйн хэт ачаалал дагуулдаг. Иймээс нийгмийн хамгаалал илүү өргөн хүрээтэй, тусгай зохицуулалттай байх шаардлагатай.
- Шилжилт хөдөлгөөн, тогтворгүй байдал: Цэргийн алба хаагчдыг байршил, томилгооны дагуу олон удаа шилжүүлдэг тул орон сууц, гэр бүл, хүүхдийн боловсрол зэрэг асуудалд тусгай бодлого хэрэгтэй.
- Эрүүл мэндийн онцгой хэрэгцээ: Цэргийн алба хаагчид өндөр эрсдэлтэй орчинд ажилладаг тул эрүүл мэндийн даатгал, эмнэлгийн тусламж нь нэмэлт хөнгөлөлт, тусгай сувиллын үйлчилгээтэй байдаг².
- Сэтгэл зүйн дэмжлэг: Байлдааны ажиллагаа, энхийг сахиулах ажиллагаанд оролцсон алба хаагчдад сэтгэл зүйн нөхөн сэргээх стресс, сэтгэл зүйн эмгэгийн эмчилгээ зайлшгүй шаардлагатай³.

Цэргийн алба хаагчдын нийгмийн хамгаалал нь дараах үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдэнэ:

1. Цалин, хөдөлмөрийн баталгаа

- Албан тушаал, цол, онцгой нөхцөлийн нэмэгдэл, урамшуулал бүхий цалин;
- Илүү цаг, өндөр ачаалал, хээрийн нөхцөл, байлдааны ажиллагааны нэмэгдэл;
- Цалинг инфляц, эдийн засгийн өсөлттэй уялдуулан шинэчлэх.

2. Тэтгэвэр, тэтгэмжийн тогтолцоо

- Тодорхой жил ажилласны дараа эрт тэтгэвэрт гарах эрх;
- Ахмад дайчдад зориулсан тусгай тэтгэвэр, хөнгөлөлт;
- Осол гэмтэл, хөдөлмөрийн чадвар алдалтад чиглэсэн тэтгэмж;

3. Эрүүл мэндийн хамгаалал

- Цэргийн эмнэлэг, сувилал, нөхөн сэргээх төвөөр үнэ төлбөргүй үйлчлүүлэх;
- Гадаад улсад эмчилгээ хийлгэх дэмжлэг;
- Алба хаагчийн гэр бүл, хүүхдийн эрүүл мэндийн даатгал;

4. Орон сууцны баталгаа

- Төрөөс орон сууцны зээл, урьдчилгааны дэмжлэг;
- Түрээсийн байр, албан тушаалын байр;
- Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой дэд бүтцийн дэмжлэг;

² *Military Personnel Policies and Social Protection Systems: Comparative Overview*. NATO Defense College. 2020

³ Hoge, C. W., Auchterlonie, J. L., & Milliken, C. S. "Mental Health Problems, Use of Mental Health Services, and Attrition From Military Service After Returning From Deployment to Iraq or Afghanistan." *Journal of the American Medical Association*, 2004. 295(9), 1023–1032.

5. Сэтгэл зүйн хамгаалалт, соёл боловсролын дэмжлэг


- Сэтгэл зүйчийн зөвлөгөө, эмчилгээний тогтолцоо;
- Байлдааны ажиллагааны дараах стрессийг даван туулах нөхөн сэргээх үйлчилгээ;
- Соёл, спорт, боловсролын хөтөлбөрөөр алба хаагч, тэдний гэр бүлийг дэмжих;

Цэргийн алба хаагчдын нийгмийн хамгаалал нь зөвхөн цалин, тэтгэврийн асуудал биш, харин тэдний эрүүл мэнд, орон сууц, сэтгэл зүй, гэр бүлийн баталгааг бүхэлд нь хамарсан иж бүрэн тогтолцоо бөгөөд үндэсний батлан хамгаалах чадавх, улс орны аюулгүй байдлын баталгаатай шууд уялдаатай ойлголт юм.

Цэргийн алба хаагчдын нийгмийн хамгааллын өнөөгийн байдал

Цэргийн алба нь онцгой нөхцөл бүхий төрийн тусгай алба тул нийгмийн хамгааллын зохицуулалт нь албан тушаал, цол зэрэглэлд суурилсан цалин, эрсдэл өндөр үүрэгтэй нь уялдсан тэтгэвэр тэтгэмж, нэмэгдэл, урамшуулал, үйлчилгээний тасралтгүй байдал (эрүүл мэнд, сэтгэл зүй, нөхөн сэргээх тусламж)-аар ялгардаг бөгөөд эдгээрийг салбарын холбогдох хуулиудаар тусгайлан зохицуулж байна.

1. Цалин, урамшуулал, нэмэгдэл



Төрийн алба хаагчдын цалин 2021 онд өсөлтгүй байсан бол 2023 онд хамгийн өндөр буюу 28.8 хувиар өсөж, дараагийн жилүүдэд 10 хувь ба 6 хувийн түвшинд тогтворжсон байна. Мөн Монгол Улсын Засгийн газрын 61 дүгээр тогтоолоор Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчдын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг албан тушаалын сарын үндсэн цалингийн 25 хувиар олгох⁴, 201 дүгээр тогтоолоор алслагдсанд тооцсон цэргийн анги, салбарт тав ба түүнээс дээш жилийн хугацаагаар алба хааж байгаа цэргийн алба хаагчид таван жил тутамд 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгох⁵, 161 дүгээр тогтоолоор Зэвсэгт хүчин, хил хамгаалах байгууллагын офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчид мэргэшлийн цэргийн нэмэгдлийг тухайн алба хаагчийн албан тушаалын сарын

⁴ Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 61 дүгээр тогтоол

⁵ Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 201 дүгээр тогтоол

үндсэн цалингаас 10-20 хувиар бодож олгохоор тогтоосон⁶. Энэ нь хүний нөөцийн тогтвортой байдлыг хангаж, алслагдсан ангид ажиллах сэдэл, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, нийгмийн хамгааллыг сайжруулах чухал ач холбогдолтой.

2. Тэтгэвэр, тэтгэмжийн тогтолцоо

Цэргийн алба хаагчийн хөдөлмөрийн онцлог байдлаас шалтгаалан 25-аас доошгүй жил алба хаасан эрэгтэй, 20-иос доошгүй жил алба хаасан эмэгтэй бол нас харгалзахгүйгээр цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгож, энэхүү тэтгэврийн харилцааг “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай” хуулиар зохицуулдаг. Энэхүү хуулийн зохицуулалтад цэргийн алба хаагчийн өдөр тутмын бүхий л үйл ажиллагаа нь дүрэм, журмаар зохицуулагддаг, цагийн хязгааргүй хөдөлмөр, байнгын бэлэн байдалд сэтгэл зүйн хүнд нөхцөлд алба хаах, гадаадад энхийг дэмжих ажиллагаанд оролцон урт хугацаагаар үүрэг гүйцэтгэх болон амь нас, эрүүл мэндийн эрсдэлийн төвшин өндөр байдгийг харгалзан тэдний эрх зүйн байдал, тэтгэвэр тэтгэмж, нийгмийн хамгааллын бусад асуудлыг тусгайлан авч үзэн хуулиар зохицуулж ирсэн. Үүнд: Онцгой нөхцөлд (цэргийн алба хаагч амь үрэгдсэн, хүнд гэмтэл авсан) гэр бүлд тусгай тэтгэмж, оршуулгын дэмжлэг үзүүлэх, тэтгэвэрт гарсан ч цэргийн алба хаагчид эрүүл мэндийн даатгалын үйлчилгээнд хамрагдах бөгөөд батлан хамгаалах байгууллагын тусгай эмнэлгийн үйлчилгээг үргэлжлүүлэн авах эрхтэй байдаг⁷. Гэвч өнөөдөр цэргийн алба хаагчийн тэтгэврийн хэмжээг инфляц, амьжиргааны өртөгтэй уялдуулахад хүндрэлтэй, тэтгэвэрт гарсаны дараах хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, орон сууцны дэмжлэгийн баталгааг хангах бодлого сул байсаар байгаа тул олон улсын сайн туршлагаас суралцаж, тэдний нийгмийн баталгааны тогтолцоог үр дүнтэй болгох шаардлагатай байна.

3. Орон сууцны хангалт, хүртээмж

Цэргийн алба хаагчдын нийгмийн хамгааллын чухал бүрэлдэхүүн нь орон сууцны баталгааг хангах явдал юм. Орон сууцны хүртээмж нь тухайн алба хаагчийн амьдралын чанар, гэр бүлийн тогтвортой байдал, алба хаах үр нөлөө буюу байгууллагын хүний нөөцийн тогтвортой байдалд шууд нөлөө үзүүлдэг. Батлан хамгаалах салбар нь өөрийн албаны орон сууцны нөөцтэй хэдий ч нийт хэрэгцээг хангахад хүрэлцэхгүй, төр-хувийн хамтын ажиллагаа, урьдчилгаа дэмжлэг зэрэг бодлогоор асуудлыг шат дараатай шийдэж байгаа юм.

Батлан хамгаалах яамны эзэмшлийн орон сууцыг тэдгээрт амьдарч буй офицер, ахлагч, ахмадуудад хувьчлах, Хуурай замын цэргийн командлалын офицер, ахлагчид зориулсан 30 айлын албан тушаалын орон сууц ашиглалтад оруулах, “150 мянган айл-Орон сууц” Үндэсний хөтөлбөртэй уялдсан дэмжлэг буюу ипотекийн хөтөлбөрт хамруулах, орон сууцны урьдчилгаа бүрдүүлэхэд 20 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэх зэргээр цэргийн алба хаагчдын орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлж ирсэн. Гэсэн хэдий ч алслагдсан бүс нутгийн орон сууцны хүртээмж, тохь тухтай амьдрах боломж муу, хот суурин газрын орон сууцны түрээсийн дарамт их, гэр бүлийн гишүүдийн амьдралын нөхцөл хангалтгүй хэвээр байна.

⁶ Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 161 дүгээр тогтоол

⁷ Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай (2016). Legalinfo.mn.

4. Эрүүл мэнд, сэтгэл зүйн үйлчилгээ

Цэргийн алба хаагчдын эрүүл мэнд нь үндэсний аюулгүй байдлын чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд тэдний бие бялдар, сэтгэл зүйн чадавх нь цэргийн бэлэн байдлыг тодорхойлдог.

Офицер, ахлагч, гэрээт цэргийн алба хаагчдын эрүүл мэндийн даатгал, эмнэлгийн тусламжийн харилцааг “Эрүүл мэндийн даатгалын тухай” хууль болон “Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай” хууль хослон зохицуулдаг⁸.

Цэргийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний үндсэн бааз нь Зэвсэгт хүчний Цэргийн төв эмнэлэг бөгөөд амбулаторийн, хэвтэн эмчлүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо шинжилгээ зэрэг цогц үйлчилгээ үзүүлдэг. Мөн цэргийн төв эмнэлэг нь цэргийн алба хаагчдын гэр бүлийн гишүүдэд анхан болон лавлагаа (нарийн оношилгоо, хүнд өвчний оношилгоо-эмчилгээ) шатны тусламж үзүүлдэг.

Харин орон нутгийн цэргийн ангиудад байрлах эмнэлгийн нэгжүүд нь анхан шатны эмнэлгийн тусламж, түргэн тусламж, бага хэмжээний мэс ажилбар, эмийн тусламж үзүүлэх боломжтой.

Мөн түүнчлэн цэргийн алба хаагчид хуулийн хүрээнд иргэний төрийн болон хувийн эмнэлгүүдийн үйлчилгээ авах боломжтой. “Эрүүл мэндийн даатгалын тухай” хуулийн 7 дугаар зүйлд “Даатгуулагч нь гэр бүлийн гишүүдийн хамт даатгалын сангаас санхүүждэг тусламж, үйлчилгээг авах эрхтэй” гэж заасан байдаг. Энэ нь цэргийн алба хаагч болон түүний гэр бүлийн гишүүдэд ижил үйлчилнэ. “Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай” хуулийн 23 дугаар зүйлд “Цэргийн алба хаагч эрүүл мэндийн даатгалд хамрагдах, улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаас үйлчилгээ авах эрхтэй” гэж заасан. Мөн энэ хуульд цэргийн алба хаагчид өөрийн онцлог үүргээс шалтгаалан эрүүл мэндийн тусгай хамгаалалт эдлэх тухай тусгасан байдаг. Энэ нь гэмтэл, хөдөлмөрийн чадвар алдалт зэрэг онцгой тохиолдолд төрөөс нөхөн төлбөр, дэмжлэг авах боломжтой гэсэн үг юм.

Сэтгэл зүйн үйлчилгээний хувьд нэгтгэл, анги байгууллагуудад сэтгэл зүйч, соёл хүмүүжлийн офицерууд ажиллаж, “Сэтгэл зүйн хангалтыг зохион байгуулах заавар”, “Зэвсэгт хүчний сэтгэл зүйн үйлчилгээний журам”-ын дагуу цэргийн алба хаагчдад анхан шатны зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, стресс, ядаргаа, цочмог сэтгэл зүйн хямралын үед шуурхай тусламж үзүүлэх чиглэлээр үүрэг гүйцэтгэж байна⁹. Мөн “Цэргийн сэтгэл зүйч, соёл хүмүүжлийн ажилтнуудын цахим зөвлөгөөн зохион байгуулах”, “Сэтгэл зүйн хөдөлгөөнт бүлэг” ажиллуулах зэргээр сэтгэл зүйн удирдлага, үйлчилгээний шинэ хэлбэрийг ашиглаж эхлээд байна. Гэсэн хэдий ч сэтгэл зүйн дэмжлэг туслалцаа үзүүлэх материаллаг бааз муу, сэтгэл зүйн оношилгоо, судалгааны сан бүрдээгүй, орон нутгийн зарим ангиудад мэргэжлийн сэтгэл зүйч хүрэлцээгүй, цэргийн алба хаагчдын дунд сэтгэл зүйн зөвлөгөө авахыг “сул дорой байдал” гэж үзэх сөрөг хандлага давамгайл буюу сэтгэл зүйн тусламж

⁸ Эрүүл мэндийн даатгалын тухай хууль. (2023), Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль. (2023). Legalinfo.mn.

⁹ “Сэтгэл зүйн хангалтыг зохион байгуулах заавар” Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2015 оны тушаал

авах соёл сул, хувь хүний нууцлалын баталгаа хангагдаагүй зэрэг нь цэргийн байгууллагад мэргэжлийн сэтгэл зүйн тусламжийн тогтолцоо бүрэн бүрдэж амжаагүй байгааг харуулж байгаа юм.

Цэргийн алба хаагчдад жил бүр эрүүл мэндийн үзлэг тогтмол хийгддэг ч оношилгоо, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хангалттай түвшинд хэрэгжүүлдэггүй, сэтгэл зүйн үнэлгээ дутмаг, сэтгэл гутрал, стресстэй холбоотой асуудлуудыг илрүүлж, эмчлэх тогтолцоо сул, нарийн мэргэжлийн тусламжийн хүрэлцээ, орон нутгийн хүртээмжийн ялгаа, энхийг сахиулах ажиллагаанд оролцсон алба хаагчдын эрүүл мэндийн хяналт, дэмжлэг дутмаг зэрэг хүндрэлүүд байсаар байна.

5. Гэр бүл боловсролын дэмжлэг

Батлан хамгаалах салбарын хүний нөөцийг тогтвортой хадгалах, цэргийн алба хаагчийн нийгмийн хамгааллыг хангах бодлогын нэг чухал хэсэг нь тэдний гэр бүлд үзүүлэх боловсролын дэмжлэг юм. “Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай” хууль-ийн 19 дүгээр зүйлд цэргийн алба хаагч, тэдний гэр бүлийн гишүүдийн нийгмийн хамгаалал, боловсролын дэмжлэгийн талаар тодорхой заасан. Тухайлбал, алба хаагчийн хүүхдийг цэцэрлэгт хамруулах, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтад тэгш хамруулахад анхаарч ажиллахыг төрийн байгууллагад үүрэг болгосон байдаг¹⁰. Үүнээс үндэслэн алслагдсан анги, салбарт үүрэг гүйцэтгэж буй алба хаагчийн хүүхдүүдийг нийслэл, аймаг, сум, дүүргийн сургууль, дотуур байранд хамруулан боловсролын тасралтгүй байдлыг хангах боломжийг бүрдүүлдэг боловч цэргийн алба хаагчийн ажлын онцлог, томилгооноос шалтгаалсан гэр бүлийн нүүдэл суудалд дасан зохицох, боловсролын тасралтгүй байдлыг хангах тогтолцоо сул, хэрэгжилт хангалтгүй байна. Мөн зарим тохиолдолд алба хаагчийн хүүхдүүдийг батлан хамгаалах салбарын сургуулиудад сургахад тэтгэлэг, хөнгөлөлт үзүүлдэг боловч дэмжлэгийн хэмжээ, хүртээмж нь хязгаарлагдмал, бага байдаг.

Цэргийн алба хаагчдын нийгмийн хамгааллын тогтолцоо: Гадаадын зарим улс орнуудын туршилагаас

1. Америкийн нэгдсэн улс

АНУ-ын Зэвсэгт хүчин нь дэлхийд хамгийн өндөр төсөвтэй армийн нэг бөгөөд алба хаагчдын нийгмийн баталгаа, эрүүл мэнд, боловсрол, тэтгэврийн асуудалд онцгой анхаарал хандуулдаг.

Tricare нэртэй эрүүл мэндийн иж бүрэн даатгалын системтэй бөгөөд зөвхөн алба хаагчид төдийгүй гэр бүлийн гишүүдийг хамардаг¹¹. Мөн GI Bill хөтөлбөрөөр дамжуулан цэргийн алба хаагч болон тэдний гэр бүлийнхэнд сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулсан санхүүжилт олгодог¹². Үүнээс гадна Veterans Affairs (VA) байгууллага нь тэтгэвэр, орон сууцны зээл, сэтгэл зүйн үйлчилгээ, нөхөн

¹⁰ Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль. (2023). Legalinfo.mn.

¹¹ U.S. Department of Defense. TRICARE Health Program Overview. Washington. 2023.

¹² U.S. Department of Veterans Affairs. Post-9/11 GI Bill (Chapter 33) Education and Training. VA.gov, 2022.

сэргээх эмчилгээ зэргийг цогцоор нь хариуцдаг¹³.

2. Холбооны бүгд найрамдах Герман улс

Герман улс нь алба хаагчдаа өндөр түвшний нийгмийн хамгаалалтай байлгах бодлого баримталдаг. Эрүүл мэндийн бүх төрлийн үйлчилгээ төрөөс бүрэн даагддаг бөгөөд цэргийн алба хаагчдын гэр бүл, хүүхдүүдийн боловсролын асуудлыг орон нутгийн сургуультай хамтран шийдвэрлэдэг¹⁴. Мөн орон сууц, тэтгэврийн бодлого нь иргэний ажилтнуудын түвшинд дүйцэхүйц, тогтвортой хамгаалалтыг бүрдүүлсэн¹⁵.

3. Бүгд найрамдах солонгос улс

Өмнөд Солонгосын Зэвсэгт хүчин сүүлийн 10 жилд алба хаагчдын цалинг хоёр дахин өсгөж, тэтгэвэрт гарах хүртэлх баталгааг төрөөс бүрэн хариуцдаг¹⁶. Гэр бүлийн нийгмийн хамгааллын хүрээнд хүүхдийн боловсрол, орон сууцны хөнгөлөлттэй зээл олгодог бөгөөд эрүүл мэндийн үйлчилгээ нь цэргийн болон иргэний эмнэлгийн хосолсон тогтолцоонд тулгуурладаг¹⁷.

4. Япон улс

Японы Өөрийгөө хамгаалах хүчний алба хаагчдын нийгмийн хамгаалал нь хууль эрх зүйн нарийн зохицуулалтад тулгуурладаг нь эрүүл мэнд, орон сууц, тэтгэвэр, боловсрол зэрэг бүх салбарыг хамарсан иж бүрэн эрх зүйн зохицуулалт юм¹⁸. Алба хаагчдын сэтгэл зүйн эрүүл мэндийг хамгаалахын тулд мэргэжлийн зөвлөгөө, эмчилгээ үзүүлэхээс гадна иргэний ажилд шилжихэд чиглэсэн Career Transition Support хөтөлбөр хэрэгжүүлдэг¹⁹.

ДҮГНЭЛТ

Цэргийн алба хаагчдын нийгмийн хамгаалал нь орон сууц, эрүүл мэнд, боловсрол, тэтгэвэр зэрэг олон талт дэмжлэгийг хамарч, алба хаагчийн болон түүний гэр бүлийн амьдралын баталгааг хангах чухал нөхцөл болдог.

Олон улсын жишгийг авч үзвэл, батлан хамгаалах бодлого нь “хүн төвтэй” чиг хандлагатай болж, цэргийн алба хаагч болон тэдний гэр бүлийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд голлон анхаардаг байна.

Хөгжингүй орнуудын цэргийн алба хаагчдын нийгмийн хамгааллын тогтолцоо нь хууль эрх зүйн баталгаатай, санхүүгийн тогтвортой эх үүсвэртэй, боловсрол, эрүүл мэнд, орон сууц, гэр бүлийн халамж зэрэг иж бүрэн үйлчилгээний хэлбэрээр хэрэгждэгээрээ онцлог байна.

Харин Монгол Улсад энэхүү тогтолцоо тодорхой хэмжээнд бүрэлдсэн ч эрх

¹³ U.S. Department of Veterans Affairs. Veterans Benefits Administration Annual Report. Washington. 2023

¹⁴ Bundeswehr. Soziale Absicherung der Soldaten. Bundesministerium der Verteidigung, <https://www.continentale.info/wp-content/uploads/2020/02/soziale-absicherung-soldaten.pdf>

¹⁵ Federal Republic of Germany. Pension and Housing Policies for Soldiers

¹⁶ Republic of Korea Ministry of National Defense. Defense White Paper. Seoul. 2022.

¹⁷ Republic of Korea Armed Forces Medical Command. Healthcare Services for Soldiers and Families. 2022.

¹⁸ Government of Japan. Defence Personnel Act. Tokyo. 2021.

¹⁹ Japan Ministry of Defense. Career Transition Support for Self-Defense Forces Personnel. Tokyo. 2022.

зүйн орчны уялдаа холбоо, төсвийн санхүүжилтийн тогтвортой байдал, алба хаагчдын гэр бүлд чиглэсэн бодлогын сул тал илэрхий байна. Түүнчлэн орон сууц, боловсролын дэмжлэгийн бодлого хязгаарлагдмал хүрээнд хэрэгжиж байгаа бөгөөд сэтгэл зүйн үйлчилгээ тогтолцооны түвшинд бүрэн хөгжөөгүй байна.

Иймд гэр бүлд чиглэсэн халамж, шилжилт хөдөлгөөнтэй уялдсан орон сууц болон боловсролын бодлогыг өргөжүүлэх шаардлагатай. Хөгжингүй орнуудын туршлагыг нутагшуулахдаа Монгол Улсын эдийн засгийн чадавхи, батлан хамгаалахын хүний нөөцийн бодлоготой уялдуулан, шат дараатай, бодит хэрэгжихүйц арга хэмжээг төлөвлөх шаардлагатай байна.

ЗӨВЛӨМЖ, САНАЛ

АНУ-ын Tricare-ийн загвараар алба хаагч болон гэр бүлийг хамарсан иж бүрэн даатгалын тогтолцоог хөгжүүлэх

Цэргийн алба хаагчдын орон сууцны хэрэгцээ ба хүртээмжийн тайланг бодитой, ил тод гаргаж, орон сууцны дэмжлэгийн баталгааг хангах бодлого боловсруулах

Барилга, инженерийн цэргийн нөөц боломжийг ашиглан, Зуунмод хотын 30 айлын төсөл шиг төслүүдийг бусад алслагдсан анги байгууллагад хэрэгжүүлэх. Ингэхдээ дэд бүтэц (цэцэрлэг, сургууль)-ийг зэрэг шийдэх боломжийг эрэлхийх.

Цэргийн гэр бүлүүд байнга нүүх, шилжин суурьших шаардлагатай болдог тул цахим сургалтын платформ, e-learning, hybrid classroom-ыг ашиглан боловсролын тасралтгүй байдлыг хангах. АНУ-ын DoDEA (Department of Defense Education Activity) цахим сургалт, шилжихэд дасан зохицох хөтөлбөрийн сайн жишээ болно.

Сэтгэл зүйн үйлчилгээний тогтолцоог цэргийн эмнэлгийн бүтэцтэй уялдуулан оношилгоо, үнэлгээ хийх системтэй болгох, түүнчлэн сэтгэцийн эрүүл мэндийн боловсролыг сургалт, хөтөлбөрөөр (электрон сургалт, цахим гарын авлага, аппликэйшн ашиглан) тасралтгүй дэмжих нь цэргийн алба хаагч болон тэдний гэр бүлийн сэтгэл зүйн дархлааг бэхжүүлэх болно.

Японы “Service family” хандлагын жишээгээр цэргийн алба хаагчийг зөвхөн төрийн албан хаагч төдийгүй эх оронч үзэл, сахилга бат, үүрэг хариуцлагын үлгэр дуурайл болсон иргэн гэж олон нийтэд таниулах, нийгэмд тэдний нэр хүнд, итгэл, хүндэтгэлийг нэмэгдүүлэх сурталчилгаа өргөн хүрээнд явуулах.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 61 дүгээр тогтоол
2. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 201 дүгээр тогтоол
3. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 161 дүгээр тогтоол
4. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай (2016). Legalinfo.mn.
5. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль. (2023). Legalinfo.mn.
6. Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль. (2023). Legalinfo.mn.
7. “Сэтгэл зүйн хангалтыг зохион байгуулах заавар” Зэвсэгт хүчний Жанжин штабын

даргын 2015 оны тушаал

8. Bundeswehr. Soziale Absicherung der Soldaten. Bundesministerium der Verteidigung. <https://www.continentale.info/wp-content/uploads/2020/02/soziale-absicherung-soldaten.pdf>
9. Federal Republic of Germany. Pension and Housing Policies for Soldiers.
10. Government of Japan. Defence Personnel Act. Tokyo. 2021.
11. Hoge. C.W., Auchterlonie. J.L. & Milliken. C.S. «Mental Health Problems, Use of Mental Health Services, and Attrition From Military Service After Returning From Deployment to Iraq or Afghanistan.» Journal of the American Medical Association. 2004. 295(9). 1023–1032.
12. Japan Ministry of Defense. Career Transition Support for Self-Defense Forces Personnel. Tokyo. 2022.
13. Military Personnel Policies and Social Protection Systems: Comparative Overview. NATO Defense College. 2020
14. Republic of Korea Armed Forces Medical Command. Healthcare Services for Soldiers and Families. Seoul. 2022.
15. Republic of Korea Ministry of National Defense. Defense White Paper. Seoul. 2022.
16. U.S. Department of Defense. TRICARE Health Program Overview. Washington. 2023.
17. U.S. Department of Veterans Affairs. Post-9/11 GI Bill (Chapter 33) Education and Training. VA.gov. 2022.
18. U.S. Department of Veterans Affairs. Veterans Benefits Administration Annual Report 2022. Washington. 2023.
19. World Social Protection Report 2017–19: Universal social protection to achieve the Sustainable Development Goals. ILO.